

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/047/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn</p> <p>Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnnyam573@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
3.1. Төлбөрийн акт.....	13
3.2 Албан шаардлага	14
3.3 Зөвлөмж	15
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	17

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

Ауд. Акт. № 198
танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭГ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАДАМЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаартай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, эм эмнэлгийн хэрэгсэлийн тайлангийн үлдэгдэл бэлэн байгаа үлдэгдэлтэй нэр төрөл, тоо ширхэг, үнийн дүнгээр зөрүүтэй 20.7 сая төгрөг, байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 1.7 сая төгрөгийн мал амьтадыг шийдвэргүйгээр зарлагадсан,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн 42.5 сая төгрөг
- Эм, эмнэлгийн хэрэгслийг төндэрийн гэрээний үнийн дүнгээс өндөр үнээр худалдаж авсан 3.9 сая төгрөг,

8426050496

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Эм, эмнэлгийн хэрэгслийг дутуу хүлээн авч төлбөрийг төлсөн, анхан шатны баримтгүй зарлагадсан, зарцуулалт нотлогдоогүй 4.3 сая төгрөг,
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тавигдсан төлбөрийн актыг төсвөөс төлсөн 3.6 сая төгрөг,
- Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй 31.7 сая төгрөг,
- Түлш шатах тослох материалын жолоочийн замын хуудасны зарцуулалтын тооцоо бодоогүй, шатахуун олгосон талноос зөрүүтэй,
- Ажилтнуудад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулаагүй

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 3715 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 35.8 сая төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал зардлаас 5.9 сая төгрөгийн, харьяа дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар 25.2 сая төгрөг, нийт 31.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 зорилго 10 хөтөлбөр, 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 95 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 91 хувиар дүгнэж, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг аймгийн Эрүүл мэндийн даатгалын газраас 85 хувиар тус тус дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,304,171.80</u>	<u>86,765,885.10</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,005,000.00	9,597,770.57
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,005,000.00	9,597,770.57
3121	Төгрөг	1,005,000.00	9,597,770.57
31211	Төрийн сангийн харилцах	1,005,000.00	9,597,770.57
33	АВЛАГА	135,717,300.00	36,487,203.34
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	632,439.05
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	133,046,124.00	35,854,764.29
335	Бусад авлага	2,671,176.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,671,176.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	37,581,871.80	40,680,911.19
351	Түүхий эд материал	23,962,754.98	20,706,908.59
35130	Эм боох материал	23,962,754.98	20,706,908.59
354	Хангамжийн материал	8,769,116.82	16,824,002.60
35410	Бичиг хэргийн материал	400,000.00	2,938,100.00
35420	Аж ахуйн материал	4,283,131.32	9,611,804.60
35460	Хүнсний материал	4,085,985.50	3,319,098.00
35470	Бусад хангамжийн материал	-	955,000.00
35600	Мал амьтад	4,850,000.00	3,150,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>730,248,882.89</u>	<u>690,326,563.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	730,248,882.89	690,326,563.56
392	Биет хөрөнгө	718,442,882.89	678,520,563.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	514,651,031.59	514,651,031.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(101,983,427.05)	(119,755,417.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,747,220.00	96,747,220.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,380,277.42)	(39,006,758.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	388,485,898.89	416,888,998.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(159,967,363.49)	(202,868,535.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,107,030.00	31,836,030.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,217,229.63)	(19,972,005.17)
393	Биет бус хөрөнгө	11,806,000.00	11,806,000.00
39301	Програм хангамж	1,007,000.00	1,007,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,007,000.00)	(1,007,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	11,806,000.00	11,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>904,553,054.69</u>	<u>777,092,448.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>30,833,177.47</u>	<u>49,051,036.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,833,177.47	49,051,036.00
413	Өглөг	30,833,177.47	49,051,036.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	21,731,769.34
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	28,034,527.47	17,230,496.53
4136	Бусад өглөг	2,798,650.00	10,088,770.13
41361	Байгууллагад төлөх өглөг	2,798,650.00	10,088,770.13

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	873,719,877.22	728,041,412.66
51	Засгийн газрын хувь оролцоо	873,719,877.22	728,041,412.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	129,079,912.00	129,079,912.00
51101	Өмч: - төрийн	129,079,912.00	129,079,912.00
512	Хуримтлагдсан үр дүн	387,285,359.02	241,606,894.46
51210	Өмнөх үеийн үр дүн	387,285,359.02	387,285,359.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(145,678,464.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,354,606.20	357,354,606.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	904,553,054.69	777,092,448.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,371,010,884.04	1,247,436,494.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	205,060,113.38	96,154,106.59
120	Нийтлэг татварын бус орлого	205,060,113.38	96,154,106.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	203,650,113.38	96,154,106.59
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	68,252,337.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	203,650,113.38	27,901,769.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,165,950,770.66	1,151,282,387.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,400,000.00	627,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,400,000.00	627,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,481,200.00	35,495,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,481,200.00	35,495,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,122,069,570.66	1,115,159,737.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,122,069,570.66	1,115,159,737.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,148,816,490.82	1,391,414,958.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,148,816,490.82	1,391,414,958.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,148,816,490.82	1,325,593,862.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,482,258.62	876,462,700.86
210101	Үндсэн цалин	383,630,083.27	471,803,789.98
210102	Нэмэгдэл	233,667,475.35	290,678,510.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,005,000.00	56,626,000.00
210104	Урамшуулал	62,179,700.00	57,354,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,272,622.97	111,565,557.30
210201	Тэтгэврийн даатгал	60,921,143.94	77,499,342.94
210202	Тэтгэмжийн даатгал	6,719,180.72	8,634,035.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,827,452.12	5,332,647.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,100,896.09	3,978,354.20

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	12,703,950.10	16,121,176.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,916,742.63	30,201,304.30
210301	Гэрэл, цахилгаан	2,615,542.63	3,445,904.30
210302	Түлш, халаалт	26,045,300.00	26,045,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,900.00	710,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,496,900.00	56,201,400.00
210401	Бичиг хэрэг	3,966,700.00	4,980,550.00
210402	Тээвэр, шатахуун	34,707,600.00	41,673,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,100.00	4,260,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,835,000.00	3,687,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,687,500.00	1,600,000.00
2105	Нормативт зардал	164,574,377.84	122,808,504.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	149,687,253.34	113,134,516.98
210502	Хоол, хүнс	12,887,124.50	9,673,987.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,270,000.00	4,440,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,090,000.00	900,000.00
210604	Урсгал засвар	12,180,000.00	3,540,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,073,994.00	1,985,000.00
210702	Дотоод албан томилолт	2,073,994.00	1,985,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,022,900.00	405,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,800.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,706,694.76	121,524,396.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,184,779.90	50,469,976.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,521,914.86	71,054,419.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	65,821,095.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	64,066,999.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	13,528,999.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	50,538,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,754,095.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,754,095.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>222,194,393.22</u>	<u>(143,978,464.56)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,170,003.00	1,700,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,170,003.00	1,700,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,170,003.00)	(1,700,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>220,024,390.22</u>	<u>(145,678,464.56)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,032,904,646.66</u>	<u>1,316,726,084.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	68,252,337.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	68,252,337.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	68,252,337.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	68,252,337.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,032,904,646.66	1,248,473,747.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,400,000.00	627,250.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,400,000.00	627,250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,481,200.00	35,495,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,481,200.00	35,495,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	989,023,446.66	1,212,351,097.21
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	989,023,446.66	1,212,351,097.21
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,040,141,623.67</u>	<u>1,308,133,313.64</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,040,141,623.67	1,308,133,313.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,040,141,623.67	1,242,312,217.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,512,837.59	856,145,551.87
210101	Үндсэн цалин	323,974,802.40	339,036,088.50
210102	Нэмэгдэл	298,442,743.54	403,582,821.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,975,950.20	56,528,458.12
210104	Урамшуулал	62,119,341.45	56,998,183.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,804,600.00	108,112,200.00
210201	Тэтгэврийн даатгал	57,667,200.00	73,668,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,784,300.00	7,512,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,392,200.00	4,488,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,392,200.00	4,488,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,568,700.00	17,953,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,996,742.63	30,201,304.30
210301	Гэрэл, цахилгаан	3,695,542.63	3,445,904.30
210302	Түлш, халаалт	26,045,300.00	26,045,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,255,900.00	710,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,920,700.00	53,548,479.87
210401	Бичиг хэрэг	2,078,000.00	2,506,579.87
210402	Тээвэр, шатахуун	34,707,600.00	34,906,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,100.00	3,300,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,085,000.00	6,085,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,750,000.00	6,750,000.00

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	112,063,349.45	120,264,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,619,349.45	114,144,800.00
210502	Хоол, хүнс	12,444,000.00	5,772,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	346,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,946,600.00	10,506,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,366,600.00	4,566,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	2,180,000.00	3,540,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,073,994.00	1,985,000.00
210702	Дотоод албан томилолт	2,073,994.00	1,985,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,447,900.00	11,028,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,025,000.00	10,623,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	131,800.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,374,900.00	50,520,881.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,374,900.00	50,520,881.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	65,821,095.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	64,066,999.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	13,528,999.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	50,538,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,754,095.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,754,095.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(7,236,977.01)	8,592,770.57
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7,236,977.01)	8,592,770.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,005,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,005,000.00	9,597,770.57

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	387,285,359.02	873,719,877.22
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	387,285,359.02	873,719,877.22

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	387,285,359.02	873,719,877.22
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	387,285,359.02	873,719,877.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	387,285,359.02	873,719,877.22
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(145,678,464.56)	(145,678,464.56)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	129,079,912.00	357,354,606.20	241,606,894.46	728,041,412.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,365,290,900.00	1,306,379,217.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,365,290,900.00	1,306,379,217.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,463,000.00	1,242,312,217.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	882,447,300.00	856,145,551.87
210101	Үндсэн цалин	313,891,100.00	339,036,088.50
210102	Нэмэгдэл	429,916,200.00	403,582,821.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,640,000.00	56,528,458.12
210104	Урамшуулал	70,000,000.00	56,998,183.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,976,500.00	108,112,200.00
210201	Тэтгэврийн даатгал	73,940,600.00	73,668,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,009,000.00	7,512,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,504,500.00	4,488,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,504,500.00	4,488,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,017,900.00	17,953,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,955,400.00	30,201,304.30
210301	Гэрэл, цахилгаан	5,200,000.00	3,445,904.30
210302	Түлш, халаалт	26,045,400.00	26,045,400.00
210303	Цэвэр, бохир ус	710,000.00	710,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,082,700.00	53,548,479.87
210401	Бичиг хэрэг	8,000,000.00	2,506,579.87
210402	Тээвэр, шатахуун	34,947,600.00	34,906,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,100.00	3,300,100.00

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,085,000.00	6,085,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,750,000.00	6,750,000.00
2105	Нормативт зардал	124,917,700.00	120,264,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,144,800.00	114,144,800.00
210502	Хоол, хүнс	5,772,900.00	5,772,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	346,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,940,000.00	10,506,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,000,000.00	4,566,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	3,540,000.00	3,540,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	1,985,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	1,985,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,151,100.00	11,028,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,000,000.00	10,623,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	487,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,992,300.00	50,520,881.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,992,300.00	50,520,881.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,827,900.00	64,066,999.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,827,900.00	64,066,999.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,553,900.00	13,528,999.96
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,634,000.00	50,538,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	640,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,365,290,900.00	1,314,971,988.51
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,495,400.00	33,741,304.30
132001	Орон нутгийн төсвөөс	35,495,400.00	33,741,304.30
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,260,763,500.00	1,212,351,097.21
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,260,763,500.00	1,212,351,097.21
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,032,000.00	68,879,587.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		627,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,027,000.00	68,252,337.00

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,005,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,005,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,597,770.57

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 109,040.9 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрч, санхүүгийн тайланд 594.4 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

Тайлант онд хүлээн авсан бараа материалыг дутуу бүртгэсэн 594.4 мян төг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 108,446.6 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрсэнд 7,899.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 64,941.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцох 35,605.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 14,852.9 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1. Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Тайлант оны эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад Пантаген буюу виталекс нэртэй дуслын шингэн тариаг 60 ш дутуу байхад 300 ш орлого авч төлбөрийг бүрэн төлсөн, мөн 300 ш зарлагадсан боловч 270 ширхэг эмийн зарцуулалт нотлогдохгүй 4,266.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Илрүүлэлт: Өмнөх онд тавигдсан 3,633.4 мянган төгрөгийн актын төлбөрийг буруутай этгээдээр төлүүлээгүй төсвөөс төлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" , 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5.”батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6.”дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1 Илрүүлэлт: Хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, эм эмнэлгийн хэрэгслийн тайлангийн үлдэгдэл бэлэн байгаа үлдэгдэлтэй нэр төрөл, тоо ширхэг, үнийн дүнгээр зөрүүтэй холбоотой 20,706.9 мянган төгрөг, байгууллагын хөрөнгөнд бүртгэлтэй 1,700.0 мянган төгрөгийн мал амьтадыг шийдвэргүйгээр зарлагдсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалын тооллогыг цаг хугацаанд нь үнэн зөв иж бүрэн хийж тооцоо бодох, эм боох материалыг нэр төрөл, тоо ширхэгээр бүртгэлд тусгах, бусдад өгөх төлбөр тооцоог өглөгийн дансаар дамжуулан давхар бичилтийн аргаар бүртгэх талаарх албан шаардлага хүргүүлэв

3.2.2 Илрүүлэлт: Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан 10,623.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд батлагдсан 32,011.2 мянган төгрөг, нийт 42,534.8 мянган төгрөгийг гүйцэтгэлээр хоол хүнс, тээвэр шатахуун, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, шуудан холбооны зардал, мэргэжлийн үйлчилгээний зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд зарцуулж, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", хоёрдугаар хавсралт "Зардлын эдийн засгийн ангиллын тайлбар"-ын Хэрэглүүрийн гуравт: "Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана", Төсвийн захирагчийн үүрэгт: "Зардлын ангиллын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Илрүүлэлт: Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас Ховд аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн 2025 оны эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур нийлүүлэх тендер зарлаж, нийлүүлэх аж ахуйн нэгжүүд болон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах нэг бүрийн үнийг тогтоож өгсөн бөгөөд тендерийн гэрээний үнийн дүнгээс өндөр үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсантай холбоотой 3,921.5 мянган төгрөг, Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 31,683.9 мянган төгрөг, нийт 35,605.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь ажил хариуцсан албан тушаалтнууд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн, иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Тээвэр шатахууны зардалтай холбоотой

Илрүүлэлт: Жолоочийн замын хуудас, шатахуун олгосон талоноос зөрүүтэй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцоог замын хуудас үндэслэн сар бүр бодож дотоод хяналтыг сайжруулах

3.3.2 Цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой асуудлаар

Илрүүлэлт: Тайлант онд илүү цагийн болон нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-р баталгаажуулахгүй олгосон зөрчил илэрлээ.

Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2-н 1 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Илүү цаг, баярын өдөр ажилласан нэмэгдэл хөлс бодож олгохдоо Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд хүлээн авсан бараа материалыг дутуу бүртгэсэн	1	594.4	1	594.4			1	594.4
Нийт дүн	1	594.4	1	594.4	0	0	1	594.4

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Пантаген буюу виталекс нэртэй дуслын шингэн тариаг 60 ширхэгийг дутуу байхад 300 ширхэгээр орлого авч төлбөрийг бүрэн төлсөн, мөн 300 ширхэгийн зарлагадсан боловч 270 ширхэг эмийн зарцуулалт нотлогдоогүй	1	4,266.0	1	4,266.0						
Өмнөх онд тавигдсан актын төлбөрийг төсвөөс эмийн зардлаас төлсөн	1	3,633.4	1	3633.4						

**Цэцэг сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, эм эмнэлгийн хэрэгсэлийн тайлангийн үлдэгдэл бэлэн байгаа үлдэгдэлтэй нэр төрөл, тоо ширхэг, үнийн дүнгээр зөрүүтэй, мал амьтадыг шийдвэргүйгээр зарлагдсан	1	22,406.9			1	22,406.9				
Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгэн зарцуулалт хийсэн	1	42,534.9			1	42,534.9				
Тендерийн гэрээний үнийн дүнгээс өндөр үнээр эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан үнийн зөрүү		3,921.5				-				3,921.5
Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендэрт шалгарсан аж ахуйн нэгжээс худалдан аваагүй,	1	31,683.9				-			1	31,683.9
Жолоочийн замын хуудас, шатахуун олгосон талоноос зөрүүтэй, тооцоо бодолгүйгээр шатахуун зарцуулсан	1	0.0					1	0.0		
Илүү цагийн болон нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-р баталгаажуулахгүй олгосон	1	0.0					1	0.0		
Дүн	7	108,446.6	2	7,899.4	2	64,941.8	2	-	1	35,605.4

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		